

БАТЛАВ.  
СОЁЛЫН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ч.ЭНХ-АМГАЛАН

МОНГОЛ УЛСЫН ИРГЭНД СОЁЛЫН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН  
АВАХ "СОЁЛЫН ЭРХИЙН БИЧИГ"-ИЙН СИСТЕМИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН  
ШИНЖИЛГЭЭ ХИЙЖ, ШИЙДЛИЙН ХУВИЛБАР ГАРГАН СИСТЕМИЙН  
ТОДОРХОЙЛОЛТ, АЖЛЫН ДААЛГАВАР БОЛОВСРУУЛАХ, ПРОЦЕССЫН  
ЗУРАГЛАЛ, БИЗНЕС ШИНЖИЛГЭЭ ХИЙХ АЖЛЫН ДААЛГАВАР

Д/д	Агуулга	
1.	Ажлын нэр:	"Соёлын эрхийн бичиг"-ийн системийн нөхцөл байдлын шинжилгээ хийж, шийдлийн хувилбар гарган системийн тодорхойлолт, ажлын даалгавар боловсруулах, процессын зураглал, бизнес шинжилгээ хийх ажлын даалгавар
2.	Захиалагч байгууллагын нэр:	Соёлын яам
3.	Хэрэгжүүлэх хугацаа:	Нийт: 30 хоног. Эхлэх: Гэрээ байгуулсан өдрөөс эхэлнэ. Дуусах: 2023 оны .....-р сарын .....-ний өдөр.

Д/д	Агуулга
4.	<p>Үндэслэл, хэрэгцээ шаардлага:</p> <p>Мэдээллийн технологийн дэвшлийг ашиглан соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлж, дижитал HUB, GLAM хэрэглэгчийн дундын системийг хөгжүүлэн, соёлын үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэх, соёлын бүтээлч үйлдвэрлэгчдийг дэмжих, салбарын Монгол Улсын эдийн засаг, нийгэмд оруулах хувь нэмэр, үр дүнг дээшлүүлэх хэрэгцээ, шаардлага бий болж байна.</p> <p>Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн судалгаа: 2021 онд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 3.7, 2022 онд 5.4 хувийг (гэмт хэргийн тоо-1102) өсвөр насны хүүхэд үйлдсэн гэмт хэрэг эзэлж байна.</p> <p>Боловсролын хүрээлэнгээс 2018 онд хийсэн “Монгол хүүхдийн хөгжлийн судалгааны тайланд “Нийт хүүхэд, залуучуудын 82.4 хувь нь 700.0 мянга хүртэл төгрөгийн орлоготой гэр бүлд амьдарч байгаа ба 17.7 хувь нь сардаа 901.0 мянгаас дээш төгрөгийн орлоготой гэр бүлд амьдарч байна.” гэсэн байна.</p> <p>НҮБ-ын 2019 оны “Монголын өсвөр үеийнхний цогц хөгжлийг ойлгох нь” нөхцөл байдлын дүн шинжилгээний Хураангуй-д “Монголын хүүхэд, өсвөр үеийнхний амьдралын талаархи тайлан, дүн шинжилгээнээс үзэхэд Засгийн газар болон түүний түншүүд бага насны хүүхдийн хөгжлийн үр дүнд бодитой ахиц дэвшил гаргаж чадсан ч өсвөр насныханд чиглэсэн хөтөлбөр дутагдаж ирсэн нь харагдаж байна.” гэжээ.</p> <p>Иймээс дээрх дээрх судалгаанаас харахад өсвөр үеийнхний чөлөөт цагаа зөв болосон өнгөрүүлэх, танин мэдэхүйн, хийж бүтээх, хамтаар амьдрах, оршихуйн соёлд суралцах бувуу соёлын боловсролыг дэмжсэн үйл ажиллагаа явуулах зайлшгүй шаардлага гарч байна.</p> <p>Иймд “Цахим соёл” арга хэмжээг Монгол Улсын холбогдох бичиг баримтуудад тусгасан нь хэрэгжүүлэх гол үндэслэл болж байна. Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> <li>- “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 1.1, 1.2, 1.3, 1.4, 1.5 дахь заалт;</li> <li>- Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 1.1, 1.2, 1.3, 1.4, 1.5 дахь заалт;</li> <li>- Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.2.1, 2.6.3.6 дахь заалт “Цахим соёл” цогц арга хэмжээ;</li> <li>- Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.2.2 дахь заалт “Бүх нийтийн соёлын боловсрол” арга хэмжээ;</li> </ul> <p>Эдгээр урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгийн арга хэмжээнд тусгагдсан ажлын хүрээнд өсвөр насны зориулсан тэдний соёлын боловсролыг дэмжсэн соёлын хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр тэдэнд</p>

Д/д	Агуулга
	<p>зориулсан эрхийн бичиг-ийг гаргах, түүнийг хэрэгжүүлэх системийг нэвтрүүлэх шаардлага үүсэж байна.</p> <p>Олон улсын хувьд ихэнх орон өсвөр насныханд зориулсан Culture Pass үйлчилгээг хэрэгжүүлж байна. Тухайлбал, Итали улс - Carta del Docente (багшийн карт): тус хөтөлбөрийн хүрээнд багшид сурагчидтайгаа хамт урлаг соёл /музей, соёлын аялал, түүхийн дурсгалт газраар зочлох, кино үзэх г.м./, боловсролын үйлчилгээ, шаардлагатай хээрлэгдэхүүн, ном сонин сэтгүүл авах боломж бүхий цахим картыг олгодог.</p> <p>Испани улс - Carné Joven (залуусын карт): залуу, өсвөр үеийг чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, театр, музей, соёл урлагийн үйлчилгээнд хамрагдахад тодорхой хэмжээний хөнгөлөлт эдлэх боломжийг олгодог.</p> <p>Их Британи улс - National Art Pass (Үндэсний урлагийн хөнгөлөлт): Их Британийн музей, урлан, түүхийн дурсгалт газарт олон төрлийн хөнгөлөлт эдлэх боломжийг олгоно.</p> <p>Канад улс - Cultural Access Pass (соёлын хүртээмжийн хөнгөлөлт): Канад улсын шинэ иргэд болон байнгын оршин суух эрх авсан шинэ иргэддээ эхний нэг жил нь улсынхаа соёл урлаг, түүхийн дурсгалт газруудад үнэгүй үйлчлүүлэх эрх бэлэглэдэг.</p> <p>Франц улс - Culture Pass Үндэсний боловсрол, залуучууд, спортын сайд, Зэвсэгт хүчний сайд, Соёлын сайд, Далайн сайд, Хөдөө аж ахуй, хүнсний сайд нар Олон нийт, засаг захиргааны хоорондын харилцааны дүрмийг харгалзан; Боловсролын тухай хууль, Мөнгө, санхүүгийн хуулийг харгалзан 2021.05.20-ны өдрийн 2021-628 дугаартай "Соёлын паспортын тухай" зарлигийг баталж, 2021.11.06-ны өдрийн сунгах тухай зарлигийг гаргасан байна.</p> <p>Иймд олон улсын туршлагыг судлан, давуу болон сул талыг тодорхойлон, өөрийн орны нөхцөл байдалд тохирсон Соёлын салбарын мэргэжилтнүүд, уран бүтээлчид өсвөр насныханд зориулсан соёлын бүтээгдэхүүн үйлчилгээ гарган эдийн засгийн эргэлтэд оруулах, нөгөө талаар өсвөр насныхан өөрийн хүсэл, сонирхол нийцсэн бүх төрлийн олон хувилбартай соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авах боломжийг бүрдүүлэх зорилго бүхий "Соёлын эрхийн бичиг"-ийн системийн нөхцөл байдлын шинжилгээ хийж, шийдлийн хувилбар гарган системийн тодорхойлолт боловсруулах, процессын зураглал, бизнес шинжилгээ хийх зөвлөх ажиллуулах зайлшгүй шаардлага гарч байна.</p>

Д/д	Агуулга	
5.	Зорилго:	<p>Соёлын салбарт мэдээллийн технологийн нэгдсэн бодлогоор мэдээллийн аюулгүй байдлыг хангасан, салбарын мэргэжилтнүүд, уран бүтээлчид өсвөр насныханд зориулсан соёлын бүтээгдэхүүн үйлчилгээ гарган эдийн засгийн эргэлтэд оруулах, цаг хугацаа, орон зайнаас үл шалтгаалан өсвөр насныхан өөрийн хүсэл, сонирхолд нийцсэн олон төрлийн, олон хувилбартай соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авах боломжийг бүрдүүлэх зорилго бүхий “Соёлын эрхийн бичиг”-ийн системийн нөхцөл байдлын шинжилгээ хийж, шийдлийн хувилбар гарган системийн тодорхойлолт, ажлын даалгавар боловсруулах, процессын зураглал, бизнес шинжилгээ хийх системийг хөгжүүлэхэд шаардлагатай мэдээллийн технологийн нөхцөл байдлыг тодорхойлж, зөвлөмж боловсруулна.</p> <p>Зөвлөх нь “Соёлын эрхийн бичиг”-ийн системийг хөгжүүлж, нэвтрүүлэхэд захиалагчид доорх чиглэлүүдээр техникийн дэмжлэг үзүүлнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>(i) Мэдээллийн технологийн орчны үнэлгээг хийж, зөвлөмж боловсруулах;</li> <li>(ii) Хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, үнэлгээ хийх;</li> <li>(iii) Олон улсын системүүдийн судалгаа, харьцуулалт, сайн туршлага</li> <li>(iv) Хэрэгцээг шаардлага, төсөвт нийцүүлэн мэдээллийн системийн архитектурын төсөл, техникийн тодорхойлолтыг боловсруулах;</li> <li>(v) Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцүүлсэн ажлын даалгаврын төслийг боловсруулах;</li> </ul>
6.	Ажлын хамрах хүрээ:	<ul style="list-style-type: none"> <li>- Соёлын яам болон холбогдох байгууллагуудын мэдээллийн технологийн орчныг үнэлэх;</li> <li>- Олон улсын системүүдийн харьцуулалт судалгааг хийх;</li> <li>- Цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх боломжтой соёлын салбарын судалгааг хийж, системийг хөгжүүлэх;</li> </ul> <p>Зөвлөх нь Соёлын яам болон түүний харьяа байгууллагууд, бусад байгууллагуудтай шууд холбогдон ажиллана.</p>
7.	Ажлын хүрэх үр дүн:	<p>Соёлын болон холбогдох бусад салбарын мэдээллийн технологийн орчны нөхцөл байдлын шинжилгээ хийснээр гарах үр дүн:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Салбарын мэдээллийн технологийн өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлж үнэлсэн байна.</li> <li>• Үйлчилгээний талаар өсвөр үеийнхний хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, үнэлсэн байна.</li> <li>• Олон улсын системүүдийн харьцуулалт судалгааг гарган, системүүдийн шийдлийг судалсан байна.</li> <li>• “Эрхийн бичиг”-ийн системийн оновчтой загварчлал, мэдээллийн системийн архитектур бүтэц бий болгосон байна.</li> </ul>

**Даалгавар 1. Соёлын яам болон холбогдох байгууллагуудын мэдээллийн технологийн орчныг үнэлж, зөвлөмж боловсруулах;**

Зөвлөх нь дараах үйл ажиллагааг гүйцэтгэсэн байна. Үүнд:

1.1 Салбарын болон бусад холбогдох салбар, нэгж байгууллагын мэдээллийн технологийн дэд бүтцийг үнэлж, зөвлөмж боловсруулна.

- Мэдээллийн технологийн тоног төхөөрөмжүүдийг үнэлэх, хэвийн найдвартай ажиллагааг хангах зөвлөмж боловсруулах;
- Одоо ашиглагдаж буй системүүдийн ажиллагаа, уялдаа холбоо, түүний үр өгөөжийг дүгнэх;
- Сервер, сүлжээний дэд бүтцийн үнэлгээ хийх, оновчтой шийдлийг санал болгох
- Цахимд суурилсан шийдэл нэвтрүүлэхэд тавигдах технологийн шаардлага, аюулгүй байдлыг хангахтай холбоотой санал, дүгнэлт боловсруулах;

**Даалгавар 2: Соёлын эрхийн бичгийн системийн процессын зураглалыг зурах.**

Зөвлөх нь дараах үйл ажиллагааг хийсэн байна. Үүнд:

2.1 Мөрдөгдөж буй хууль дүрэм, олон улсын конвенцын судалгааг хийж, холбогдох заалтуудын уялдаа холбоог гаргах;

2.2 Соёлын эрхийн бичгийн талаар олон улсын системийн шийдлийн талаар олон улсын туршлагыг судлах

2.3 Салбар дундын зохицуулалт, өнөөгийн байдалд бизнес шинжилгээ хийх;

2.4 Бизнес шинжилгээнд үндэслэн хариуцагч болон оролцогчийн үүрэг хариуцлагыг хууль эрх зүйн талаас нь гаргах;

2.5 Одоо мөрдөгдөж байгаа хууль дүрэм, журмын уялдаа холбоонд үндэслэн сайжруулах дүрэм журмын санал, заалтыг гаргах;

**Даалгавар 3: Цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх боломжтой соёлын салбарын судалгааг хийж, системийг хөгжүүлэхэд шаардлагатай зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврын төслийг боловсруулах.**

3.1 Салбарын хэмжээнд одоо ашиглаж байгаа, цахимаар үзүүлж буй үйлчилгээ, мэдээллийн системүүдэд дүн шинжилгээ хийх;

3.2 Салбар хоорондын уялдааг хангасан үйл ажиллагааны зохицуулалтыг тодорхой тусгасан цахим хэлбэрээр хүргэх боломжтой үйлчилгээний системийн үйл ажиллагаа, техникийн шаардлага болон бусад холбогдох шаардлагуудыг багтаасан системийн тодорхойлолт (ажлын даалгавар)-ыг боловсруулах;

Д/д	Агуулга	
8.	Ажлыг гүйцэтгэх зөвлөхөд тавих шаардлага:	<p>Зөвлөх компанид дараах шаардлага тавигдана:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Мэдээллийн технологийн чиглэлээр бакалавр ба түүнээс дээш зэрэг эзэмшсэн байх;</li> <li>- Төслийн менежментийн туршлагатай байх, үүнд программ хангамжийн төслийг удирдан, амжилттай хэрэгжүүлсэн байх;</li> <li>- Холбогдох талуудын ажлын уялдааг хангах, мэдээллээр хангах, хамтран ажиллах харилцааны удирдах ур чадвартай, асуудал шийдвэрлэх чадвар эзэмшсэн байх;</li> <li>- Асуудлыг цогцоор нь шийдвэрлэх, асуудалд дүн шинжилгээ хийх өндөр ур чадвартай, төрийн бодлого боловсруулах түвшинд ажиллаж байсан туршлагатай;</li> <li>- Технологийн архитектур, аппликейшн архитектур боловсруулах чадвартай байх;</li> <li>- Тайлагнах, бусдад ойлгуулах, илтгэх, харилцааны өндөр чадвартай байх;</li> </ul>
9.	Судалгааны тайлангийн үе шат, гүйцэтгэлийн баримт бичигт тавигдах шаардлага:	<p>Зөвлөх үйлчилгээ нь гэрээ байгуулснаас хойш 30 хоногийн хугацаанд хэрэгжих бөгөөд Даалгаврын 1; 2; 3-т тусгагдсан ажлууд гэрээний хугацаанд бүрэн хийгдсэн байна.</p> <p>Зөвлөх нь тайлан болон гүйцэтгэлийн баримт бичгийг 2 хувь цаасан болон цахим хэлбэрээр гаргаж өгнө.</p> <p>Зөвлөх нь доорх баримт бичгүүдийг гаргаж захиалагчид гаргаж өгнө. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Соёлын яам болон холбогдох байгууллагын мэдээллийн технологийн орчны үнэлгээ, зөвлөмж <ul style="list-style-type: none"> <li>- Мэдээллийн технологийн дэд бүтэц, системийн үнэлгээ, зөвлөмж;</li> </ul> </li> <li>2. Соёлын эрхийн бичгийн системийн процессын зураглалыг зурах; <ul style="list-style-type: none"> <li>- Мөрдөгдөж буй хууль дүрэм, олон улсын конвенцын судалгааг хийж, холбогдох заалтуудын уялдаа холбоог гаргасан судалгаа;</li> <li>- Соёлын эрхийн бичгийн олон улсын туршлагын талаарх мэдээлэл, тайлан, дүгнэлт;</li> <li>- Одоо мөрдөгдөж байгаа хууль дүрхэм, журмын уялдаа холбоонд үндэслэн сайжруулах дүрэм журмын санал, заалтын төсөл;</li> </ul> </li> <li>3. Цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх боломжтой соёлын салбаруудын судалгаа болон цахим үйлчилгээний системийг хөгжүүлэхэд шаардлагатай зөвлөх үйлчилгээний ажлын даалгавар. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>- Одоогийн нөхцөл байдлын судалгаа, зөвлөмж</li> <li>- Систем хөгжүүлэх гүйцэтгэгчид тавигдах ерөнхий шаардлага;</li> <li>- Гүйцэтгэгчид тавигдах тусгай шаардлага;</li> <li>- Системийн загварчлал болон техникийн тодорхойлолт;</li> <li>- Цахим хэлбэрээр үзүүлэх үйлчилгээний системийн тодорхойлолт;</li> </ul> </li> </ol>

Д/д	Агуулга	
10.	Боловсруулах хугацаа, тайлангийн бүрдэл:	<p>Захиалагч, гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээний нөхцөлийг үндэслэл болгон гүйцэтгэх хугацааг тооцно.</p> <p>1. <u>Дунд хугацааны тайлан:</u>  Гэрээ байгуулснаас хойш 14 хоногийн дотор буюу 2023 оны 11-р сарын .....-ны өдрөөс өмнө дараах ажлуудыг гүйцэтгэн захиалагч талд хүлээлгэн өгнө. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Соёлын яам болон холбогдох байгууллагын мэдээллийн технологийн орчны үнэлгээ, зөвлөмж;</li> <li>- Мөрдөгдөж буй хууль дүрэм, олон улсын конвенцын судалгааг хийж, холбогдох заалтуудын уялдаа холбоог гаргасан судалгаа;</li> <li>- Соёлын эрхийн бичгийн системийн талаар олон улсын туршлагын тайлан мэдээлэл, дүгнэлт, санал зөвлөмж;</li> </ul> <p>- <u>Эцсийн тайлан:</u>  Гэрээ байгуулснаас хойш 30 хоногийн дотор буюу 2023 оны 12-р сарын .....-ний өдрөөс өмнө дараах ажлуудыг гүйцэтгэн захиалагч талд хүлээлгэн өгнө. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Ажлыг тайлагнах буюу хүлээлгэж өгөх;</li> <li>- Соёлын эрхийн бичгийн системийн нөхцөл байдлын шинжилгээ, зөвлөмж;</li> <li>- Соёлын эрхийн бичгийн системийн салбар дундын процессын зураглал /салбар дундын зохицуулалт/;</li> <li>- Систем хөгжүүлэх гүйцэтгэгчид тавигдах ерөнхий шаардлага;</li> <li>- Гүйцэтгэгчид тавигдах тусгай шаардлага;</li> <li>- Системийн загварчлал болон техникийн тодорхойлолт;</li> <li>- Цахим хэлбэрээр үзүүлэх үйлчилгээний системийн тодорхойлолт;</li> </ul>

--oOo--